



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 316

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, 2019 оны 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Архангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн нийт 6,331,376.00 (зургаан сая гурван зуун гучин нэгэн мянга гурван зуун далан зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. “Архангай-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ю.Ганзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлын хэсэг томилж, холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2019 оны 3 дугаар улиралд багтаан тайлангийн маягтаар ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТ ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Ц.ТҮВШИНЗАЯА



0000563



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 07 дугаар сарын 1-ний өдрийн 378 дугаар тогтоол

“Хангай-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэл

Тээврийн хэрэгсэлийн марк, улсын дугаар, хөрөнгөтэй, хөдөлгөөн, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	
2561 маркийн 11-85 АРА н дугаартай, автокран ын дугаар 2409996, үүрийн дугаар -433744	1985/1986	306000	6,331,376.00	6,331,376.00	0.00		5
			6,331,376.00	6,331,376.00	0.00	0.00	5
Т ХӨРӨНГИЙН ДҮН			6,331,376.00 (зургаан сая гурван зуун гучин нэгэн мянга гурван зуун далан зургаан)	6,331,376.00 (зургаан сая гурван зуун гучин нэгэн мянга гурван зуун далан зургаан)			5 (т